

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсад усны хэрэглээ хотжилт, хүн амын өсөлт, үйлдвэрлэлийн хөгжлөөс шалтгаалан тогтвортой нэмэгдэж, усны нөөцөд үзүүлэх дарамт эрчимжиж байна.

Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт нийтдээ 223 байгууллага, аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа эрхэлж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудад 11,869 ажилтан ажиллаж, нийтийн орон сууцны зориулалттай 7 мянга гаруй барилгын ашиглалтын үйл ажиллагааг хариуцаж, жилдээ 176.5 сая метр куб ус олборлон 3773 км урттай шугамаар түгээж, хэрэглээнээс гарсан бохир усыг 1875 км урттай шугамаар татан зайлуулж, цэвэршүүлэн ажилладаг.

Нийслэл Улаанбаатар хотын усны хоногийн хэрэглээ 160-180 мянган метр куб хүрсэн бөгөөд цаашид өсөх хандлагатай байна. Үйлдвэрлэлийн салбар, ялангуяа эрчим хүчний салбар нь жилд 14-18 сая метр куб ус ашиглаж байгаа нь унд ахуйн зориулалтын гүний усны нөөцөд өндөр ачаалал үүсгэж байна. Нөгөө талаас цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн хаягдал усны ихээхэн нөөц эдийн засгийн эргэлтэд орохгүй байна. Энэхүү нөөцийг цэвэрлэж үйлдвэрлэл, техникийн зориулалтаар ашиглах боломжтой боловч эрх зүйн зохицуулалт байхгүй, тарифын тогтолцоо бодит зардлыг тусгадаггүй, институцийн уялдаа хангалтгүй зэрэг шалтгаанаар бодит хэрэглээнд нэвтрэх боломж хязгаарлагдмал байна.

Ийм нөхцөлд усны нөөцийг хамгаалах, үйлдвэрлэл техникийн усны хэрэглээг оновчтой болгох, хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах тогтолцоог бүрдүүлэх, салбарын эдийн засаг болон институцийн тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна. Хуулийн төслөөр хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах тогтолцоог эрх зүйн түвшинд шинээр бий болгож, дахин ашиглах цэвэрлэсэн усны үйлдвэрлэл, дамжуулалт, хэрэглээний харилцааг зохицуулах, үйлдвэрлэлийн зориулалтаар гүний цэнгэг ус ашиглахыг үе шаттайгаар хязгаарлах, усны чанар, аюулгүй байдлын шаардлага, хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, тариф, үйлчилгээний төлбөрийг зардалд суурилсан ил тод тогтолцоонд шилжүүлэх зохицуулалтыг тусгасан. Мөн эрчим хүчний салбарт дахин ашиглах

цэвэрлэсэн ус ашиглах тусгай зохицуулалтыг нэвтрүүлж, салбарын ус ашиглалтын эх үүсвэрийг хаягдалгүй ногоон эх үүсвэрт шилжүүлэх бодлогын хэрэгжүүлэх эрхзүйн үндсийг бүрдүүлсэн.

Хуулийн төсөл батлагдсанаар усны нөөцийг илүү үр ашигтай дахин ашиглах, гүний цэнгэг усны хэрэглээг бууруулах, ундны усны эх үүсвэрийн нөөцийг хамгаалах, хаягдал бохир усны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, үйлдвэрлэлийн усны ашиглалтыг ногоон эх үүсвэрт шилжүүлэх нөхцөл бүрдэнэ. Улмаар салбарын тарифын тогтолцоо бодит өртөгт суурилж, санхүүгийн тогтвортой байдал сайжирч, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж бүрдэхийн зэрэгцээ ус хангамжийн үйлчилгээний найдвартай байдал, хүртээмж дээшилж, нийтийн эрүүл мэнд, байгаль орчны хамгаалалтад эерэг үр нөлөө үзүүлнэ. Цэнгэг усны нөөцийн хомсдолд орох эрсдэл нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах тогтолцоог эрх зүйн түвшинд хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд энэхүү хуулийн төсөл нь салбарын тогтвортой хөгжлийг хангах, усны нөөцийг хамгаалах стратегийн ач холбогдолтой зохицуулалт болж байна.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ